



“ Э-Транс логистикс ” ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 08 сарын 16 -ны өдрийн
5.... тоот тогтоолын хавсралт

3300666-СБТ21530
ДОРНОДСҮРЭН АИМАГ

КОМПАНИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Энэхүү баримт бичгээр компанийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг тодорхойлно.
2. Бодлогын баримт бичгийн зорилго нь компанийн хувьцаа эзэмшигч, ажилтан, хэрэглэгч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, зохицуулагчтай хэрхэн харилцах, хамтын ажиллагааг тодорхойлоход оршино.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. ТУЗ энэхүү бодлогын баримт бичгийг баталж, хяналт тавьж ажиллана.
- 2.2. Компанийн гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, тэдгээрийн дагуу тодорхой ажил зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд компанийн эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулан хариу өгөх үйл ажиллагааг зохион байгуулах замаар бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3. Компанийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа цахим хуудсыг үр дүнтэйгээр ашиглана.

ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУД

- 3.1. Хувьцаа эзэмшигчийг компанийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэгч гэдэг утгаар нь түүний хууль тогтоомжид заасан эрхийг хүндэтгэн тэгш хандаж, компанийн талаар мэдээлэл авах болон бусад эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрэн хангаж компанийн ТУЗ хэрэгжилтэд нь хяналт тавина.
- 3.2. Ажилтныг компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэдэг утгаар нь түүнтэй харилцахдаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд харилцана.

3.2.1. хөдөлмөрийн дотоод журамд ажилтны эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх зохицуулалтыг тусгах ба хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй байх;

3.2.2. ажилтны гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ ажилтанд ашигтай байдлаар шийдэх.

3.3. Хэрэглэгч, харилцагчийг компанийн орлогыг бүрдүүлэгч гэсэн утгаар нь тэдний хэрэгцээг чанар, тоон үзүүлэлтээр бүрэн хангах зорилго бүхий байгууллагын соёлыг бүрдүүлж ажиллана.

3.3.1. хэрэглэгч, харилцагчтай харилцах харилцаанд гарсан зөрчил, маргааныг эв дүйгээр тохиролцож, харилцан буулт хийх замаар шийдэх.

3.4. Бэлтгэн нийлүүлэгчийг компанийн үйл ажиллагааны эх үүсвэр /түүхий эд, бараа материал/-ээр хангагчт гэсэн утгаар нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн

хэрэгжүүлнэ

3.4.1. хэрэглэгч, харилцагчтай харилцах харилцаанд гарсан зөрчил, маргааныг эв дүйгээр тохиролцож, харилцан буулт хийх замаар шийдэх;

3.4.2. харилцан тохиролцож шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлэх.

3.5. Холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангаж, зохицуулагч, төрийн байгууллагад тайлан мэдээг цаг тухайд нь хүргүүлнэ.

3.5.1. зохицуулагч, төрийн байгууллагатай харилцах харилцаанд цахим хэрэгслийг ашиглах

3.5.2. хууль тогтоомж зөрчсөн аливаа үйлдэл гаргахгүй байх

ДӨРӨВ. БУСАД

4.1. ТҮЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.